



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

᠖᠒ оны 1᠐ сарын ᠘᠘ өдөр

Дугаар 1/196.

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/189 дүгээр тушаалаар батлагдсан “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Ази, Номхон далайн асуудал хариуцсан төлөөлөгчид үндэсний зохицуулалтын тогтолцоог сайжруулах болон жишиг үнэлгээний арга хэрэгслийг танилцуулах ажлаар ирж байгаатай холбогдуулан “Ажлын хэсэг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга	Л.Зэндмаа	Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга
Гишүүд	Г.Номин	Чанарын хяналтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	П.Цэцгээ	Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Г.Цэцэнсанаа	Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Т.Мөнхтуул	Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга
	Д.Бямбадорж	Эмийн үйлдвэрийн хэлтсийн дарга
	Р.Энхсүрэн	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ш.Энхзаяа	Эм шинжлэх лабораторийн дарга
Нарийн бичиг	М.Долгион	Эмийн бүртгэлийн зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Б.Тэмүүлэн	Гадаад хамтын ажиллагаа, гэрээний асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Үндэсний зохицуулалтын тогтолцоог сайжруулах болон жишиг үнэлгээний арга хэрэгслийн танилцуулах хөтөлбөрт орсон ажлуудыг үнэлүүлэхэд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас шаардлагатай бэлтгэл ажлыг хангахыг Ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА